



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 678

Улаанбаатар хот

Төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.11.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан өртөг зардлыг бууруулах, нөөцийг нэмэгдүүлэх, үр ашгийг сайжруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шаардлагатай хөгжлийн зээл болон бусад эх үүсвэрийн талаар судалж, 2021 оны эхний хагас жилд багтаан танилцуулж, шийдвэрлүүлэхийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ